



SWEDISH ENVIRONMENTAL
PROTECTION AGENCY



ХЭҮК



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

БАЙГАЛЬ
ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

УУЛ УУРХАЙ,
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН
ЯАМ



БАЙГАЛЬ ОРЧНЫ ТОГТВОРТОЙ УДИРДЛАГЫГ ХАНГАХ БАЙГАЛЬ ОРЧНЫ ЗАСАГЛАЛ (SEPA EGP)

НҮБ-ЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

ТӨСЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН **2020**



ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсад уул уурхайн салбар 90 гаруй жилийн өмнөөс үүсэж хөгжиж ирсэн. Экспортын чиг хандлагатай үйлдвэрлэлийг дэмжих бодлогын хүрээнд уул уурхайн үйлдвэрлэлийг Монгол Улсын эдийн засгийн тэргүүлэх салбар болгон тодорхойлсон бөгөөд уул уурхайн үйлдвэрлэлийн өсөлттэй зэрэгцэн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой шинэ харилцаа бий болж, төрөөс хэрэгжүүлэх бодлого, зохицуулалт, хяналт, хэрэгжилтийг сайжруулах нь тулгамдсан асуудал болоод байна. Уул уурхайн үүдэлтэй байгаль орчны доройтол, хүний эрхийн зөрчил гарсаар байна.



ЗОРИЛГО

Шведийн Байгаль Хамгаалах Агентлагийн санхүүгийн дэмжлэгээр НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр нь хөгжиж буй зорилтот 10 улсын уул уурхайн салбар дахь байгаль орчин, хүний эрхийг хамгаалах хууль эрхзүйн орчин, хэрэгжилтийн тогтолцоог сайжруулан, талуудын олон талт хамтын оролцоог дэмжин, хариуцлагын механизмыг бэхжүүлснээр тус салбар дахь байгаль орчны засаглал, хяналтын тогтолцоог бэхжүүлэх зорилготой төслийг хэрэгжүүлж байна.

ТӨСЛИЙН НЭР	БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ТОГТВОРТОЙ УДИРДЛАГЫГ ХАНГАХ БАЙГАЛЬ ОРЧНЫ ЗАСАГЛАЛ
Тайлант хугацаа	2020
Хэрэгжүүлэгч байгууллага:	НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр
Шведийн Байгаль Хамгаалах Агентлаг	15 хувь
Хамтрагч байгууллага:	БОАЖЯ, УУХҮЯ, МХЕГ, ХЭҮК
Жилийн төсөв:	USD 100,000
Санхүүжилтийн эх үүсвэр:	Шведийн Байгаль Хамгаалах Агентлаг
НҮБХХ-ийн холбогдох ажилтан	Р.АРИУНБИЛЭГ Төслийн үндэсний зохицуулагч И-мэйл: riunbileg.radnaa@undp.org Tel: 976-99082949; 976-317585 Л.БАРХАС Хөтөлбөрийн ахлах ажилтан И-мэйл: barkhas.losolsuren@undp.org Tel: 976-317585

2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

“Байгалийн нөөцийн тогтвортой удирдлагыг хангах байгаль орчны засаглал” төсөл 2020 онд уул уурхайн салбарт байгаль орчныг хамгаалах, хүний эрхийг хангах хууль эрхзүйн тогтолцоо, хэрэгжилтийн механизмыг сайжруулах, талуудын хамтын оролцоо, хариуцлагын зарчим, хамтын ажиллагааг бэхжүүлэхэд чиглэсэн 5 зорилтын хүрээнд үндэсний хэрэгжүүлэгч талуудын хэрэгцээ шаардлага, бодлого хөтөлбөртэй уялдсан тодорхой үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэв.

Үүний үр дүнд төсөл хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаа оролцооны механизм тодорхой хэмжээнд сайжирч, хамтын оролцоот байгаль орчны мониторинг, хариуцлагатай уул уурхай, хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээний практикт суурилсан, үндэсний онцлогт тохирсон гарын авлага, аргачлал бий болж, уул уурхайн компаниудад нэвтэрч эхлээд байна.



ЗОРИЛТ	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХАМТРАГЧ БАЙГУУЛЛАГУУД
1. Уул уурхайн салбарт байгаль орчныг хамгаалах, хүний эрхийг хангах талаарх хууль эрхзүйн тогтолцоо, хэрэгжилтийн механизмыг сайжруулах	1.1. БОНБУ-ний тогтолцоог сайжруулах суурь үнэлгээ хийх;	БОАЖЯ
	1.2. БОМТ-ний цахим мэдээллийн сан бий болгох ажилд дэмжлэг үзүүлэх	БОАЖЯ
	1.3. Бизнес ба Хүний Эрхийн Үндэсний Хөтөлбөр боловсруулах суурь үнэлгээ хийх	ГХЯ, ХЭҮК
	1.4. Уул уурхайн улмаас байгаль орчин доройтож, экологийн хохирол учирч буй газруудад хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх	ХЭҮК
	1.5. Холбогдох асуудлаар семинар, хэлэлцүүлэг зохион байгуулах	БОАЖЯ, ГХЯ
2. Зорилтот газруудад Хамтын Оролцоот Байгаль Орчны Мониторинг (ХОМ) нэвтрүүлэх жишиг үйл ажиллагаа туршин хэрэгжүүлэх	2.1. Зорилтот газруудад төсөл хэрэгжүүлэгч талуудын оролцоотой ХОМ-ын үйл ажиллагаа туршиж хэрэгжүүлэх	БОАЖЯ, УУХҮЯ, МХЕГ, ХЭҮК
	2.2. Зорилтот газруудад иргэний нийгмийн байгууллага болон орон нутгийн санаачилгатай ХОМ-ын жишиг үйл ажиллагаа туршиж хэрэгжүүлэх	БОАЖЯ, УУХҮЯ, МХЕГ, ХЭҮК
	2.3. Жишиг үйл ажиллагаануудын туршлагад тулгуурлан уул уурхайн төсөл дээр ХОМ хэрэгжүүлэх жишиг практик гарын авлага бий болгох;	БОАЖЯ, УУХҮЯ, МХЕГ, ХЭҮК
	2.4. Орон нутгийн оролцогчдод ХОМ-ын гарын авлага ашиглах сургалт зохион байгуулах;	БОАЖЯ, УУХҮЯ, МХЕГ, ХЭҮК
3. “Хариуцлагатай уул уурхайн жишиг шаардлага”-ыг нэвтрүүлэх жишиг үйл ажиллагаа туршин хэрэгжүүлэх	3.1. “Хариуцлагатай уул уурхайн жишиг шаардлага”-ыг уул уурхайн компаниудад нэвтрүүлэх сургалтын модуль боловсруулах, сургагч багш бэлтгэх	МХЕГ, УУХҮЯ
	3.2. Зорилтот газруудад “Хариуцлагатай уул уурхайн жишиг шаардлага”-ыг туршин хэрэгжүүлэх	МХЕГ, УУХҮЯ
	3.3. Сайн туршлага, жишээнүүдийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах, хөхиүлэн дэмжих үйл ажиллагаа	МХЕГ, УУХҮЯ
4. Уул уурхайн салбар дахь байгаль орчны засаглалын оролцогч талуудыг чадавхжуулах	4.1. Орон нутгийн захиргааны байгууллагын ажилтнуудад зориулсан сургалт;	БОАЖЯ
	4.2. Хууль хяналтын байгууллагын ажилтнуудад зориулсан сургалт;	БОАЖЯ
	4.3. Сургалтын гарын авлага, материал, хэрэглэгдэхүүн боловсруулан гаргах;	БОАЖЯ, УУХҮЯ, МХЕГ, ХЭҮК
5. Төслийн Удирдах зөвлөл болон хэрэгжүүлэгч талуудын холбогдох мэргэжилтнүүдээс бүрдсэн төслийн багийн уулзалт, хэлэлцүүлэг	5.1. Удирдах зөвлөлийн хурал	БОАЖЯ, УУХҮЯ, МХЕГ, ХЭҮК
	5.2. Мэргэжилтнүүдийн уулзалт	БОАЖЯ, УУХҮЯ, МХЕГ, ХЭҮК
	5.3. Уул уурхайн форумын үеэр танилцуулах арга хэмжээ зохион байгуулах	УУХҮЯ

ТӨСЛИЙН ҮЙЛ 2020 АЖИЛЛАГААНЫ БИЕЛЭЛТ

1 УУЛ УУРХАЙН САЛБАРТ БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ ТАЛААРХ ХУУЛЬ ЭРХЗҮЙН ТОГТОЛЦОО, ХЭРЭГЖИЛТИЙН МЕХАНИЗМЫГ САЙЖРУУЛАХ

1.1 БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТОГТОЛЦООГ САЙЖРУУЛАХ СУУРЬ ҮНЭЛГЭЭ



Монгол Улсын иргэний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, хүний үйл ажиллагааны улмаас байгаль орчны тэнцвэрт байдал алдагдахаас сэргийлэх, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатайгаар байгалийн нөөц ашиглах үйл ажиллагааг зохицуулах үндсэн арга механизм нь Байгаль Орчинд Нөлөөлөх Байдлын Үнэлгээ (БОНБУ)-ний тогтолцоо бөгөөд үүгээр дамжуулан байгаль орчныг хамгаалах бодлогыг хэрэгжүүлж байна.

БОНБУ-ний одоогийн тогтолцоо, хэрэгжүүлэх механизмын бүтээмжийн үнэлгээг хийх төслийн зөвлөх 4-7-р сард БОАЖЯ-нд ажиллаж суурь үнэлгээг хийж, дүн шинжилгээг боловсруулсан. Үнэлгээний тайланг холбогдох талуудаар хэлэлцүүлэхээр төлөвлөсөн боловч КОВИД-19 вирусийн хөл хорионоос шалтгаалж хойшлоод байна. Энэхүү суурь үнэлгээ нь БОНБУ-ний эрх зүйн орчныг боловсронгуй болгох, бүтээмжийг сайжруулахад суурь мэдээлэл болох юм.

Суурь үнэлгээний тайланд дурдсанаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын үнэлгээний шинжээчдийн ажлын ачаалал асар их, төсөлд ерөнхий үнэлгээ хийх болон нэгж үнэлгээний тайланд зарцуулах цаг бага байна. Энэ нь стратегийн ач холбогдолтой уул уурхай, боловсруулах, баяжуулах үйлдвэрлэл, дэд бүтцийн томоохон төслүүдэд хийгдэх үнэлгээний шинжилгээний чанарт сөргөөр нөлөөлөх эрсдэлийг бий болгодог.

Цаашид, Монгол Улсын Үндсэн хуульд орсон нэмэлт өөрчлөлт болон одоогийн бодит нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, БОНБУ-ний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар байгаль орчны үнэлгээний төслийн ангиллыг оновчтой хуваарилах, орон нутгийн байгаль орчны төрийн захиргааны байгууллагуудыг уялдааг хангах, тэдэнд орон нутагт хэрэгжих зарим төсөлд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх, шийдвэр гаргах, эрх бүхий байгууллагын хийсэн тайланг хэлэлцэн шийдвэрлэх эрхийг олгох байдлаар төвлөрлийг сааруулан ажлын ачааллыг тэнцвэржүүлэн, үнэлгээний чанарыг дээшлүүлэх боломжтой гэж үзсэн байна.

Энэ зорилтын хүрээнд хуулийн хавсралтад заасан төслийн ангиллыг улам боловсронгуй болгох, оновчтой тодорхойлох, аймаг, нийслэлд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг хэлэлцэн шийдвэрлэх дэд зөвлөл байгуулах боломжийг судалж, ерөнхий бүтцийг тодорхойлох, чадавхжуулах боломжийн талаар санал боловсруулах шаардлагатай болно.


Дээрх зорилтыг хангаснаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Байгаль орчны стратегийн үнэлгээ, Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ, үндэсний хэмжээний том төслүүдийн Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ болон Дүйцүүлэн хамгаалах бодлогын хэрэгжилтийг хангах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох үүргээ бүрэн хэрэгжүүлэх боломж нь нэмэгдэн, үнэлгээний чанар хүртээмж сайжран, талуудын оролцоог бүрэн хангах ач холбогдолтой эрхзүйн томоохон шинэчлэлт болно гэж үзэж байна.

МЭРГЭЖЛИЙН БОЛОН МЭРГЭЖЛИЙН ДЭД ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ		Хурлын хуваарь	
Ерөнхий үнэлгээний дүгнэлт	745	МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛ	МЭРГЭЖЛИЙН ДЭД ЗӨВЛӨЛ
Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ	824	<ul style="list-style-type: none"> 22 JAN 25 JAN 2 APR 16 MAY 11 JUNE 8 JULY 30 AUG 29 OCT 5 DEC 	<ul style="list-style-type: none"> 21 JAN 21 JAN 1 APR 22 APR 17 MAY 13 JUNE 9 JULY 29 AUG 31 OCT 6 DEC
Нийт	1569		

БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ БАТЛАГДСАН ТАЙЛАН



БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ, АУДИТЫН ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ НАР



Д. Шижир-Эрдэнэ
Д. Тэмүүлэн
Б. Мөнхтуяа
Н. Анхтуяа
Н. Эрдэнэчимэг
Б. БАТБАЯР

2019 онд БОНБУ-ний тайланд хийсэн шүүмж

Мэдээллийн эх сурвалж: Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэдээллийн сан www.eic.mn

2019 онд ажлын 250 хоног

260 тайлан

- Ажлын 250 хоногт нэг мэргэжилтэн 260 тайлангийн дүгнэлт болон нарийвчилсан үнэлгээний тайланд шүүмж хийж байна.
- Ажлын 250 хоногт Дунджаар нэг мэргэжилтэнд ажлын нэг өдөрт 2 тайлантай танилцаж байна.



1.2 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний цахим мэдээллийн сан бий болгох ажилд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ), түүний биелэлтийн тайлангийн цахим мэдээллийн сан бий болгох ажлын хүрээнд аж ахуйн нэгж, байгууллагуудаас БОАЖЯ-нд сүүлийн жилүүдэд ирүүлсэн, хянагдсан хэвлэмэл тайлангуудыг сканердан файл үүсгэх ажлыг гүйцэтгэх төслийн зөвлөх 4-9-р сард БОАЖЯ-нд ажилласан. Ажил гүйцэтгэхэд шаардлагатай сканер-принтерийг худалдаж авч өгсөн. Энэ ажлын хүрээнд БОАЖЯ-ны 2018-2020 онуудад аж ахуйн нэгж байгууллагуудаас цаасаар хүлээн авсан 196 боть буюу 581 ширхэг БОМТ болон түүний биелэлтийн тайланг сканердан цахим сан үүсгэхэд бэлэн болгов. Цаашид бэлэн болсон файлуудыг цахим мэдээллийн санд оруулах ажлыг БОАЖЯ хариуцан гүйцэтгэх ба цахим сан үүсгэснээр БОМТ, тайлан хянан батлагдсан талаарх лавлагаа гаргах мэдээллийн чухал бааз суурь бий болох юм.

1.3 Бизнес ба Хүний Эрхийн Үндэсний Хөтөлбөр Боловсруулах Суурь ҮНЭЛГЭЭ

2011 онд НҮБ-ын Хүний Эрхийн Дээд Комиссарын Газраас хариуцлагатай бизнесийн зарчмуудыг дэмжих, цаашид хэрэгжүүлэх талаарх дэлхийн хамгийн нөлөө бүхий суурь зарчим болох "НҮБ-ын Бизнес ба Хүний эрхийн удирдах зарчмууд"-ыг батлан гаргасан. Хүний эрхийг хамгаалах төрийн үүрэг, бизнесийн байгууллагын хүний эрхийг хүндэтгэх хариуцлага болон зөрчигдсэн эрхийг сэргээх механизм гэсэн гурван гол тулгуур бүхий уг зарчмуудад үндэслэн улс орон бүр өөрийн онцлогт тохирсон Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж байна. Монгол Улс 2018 онд ГХЯ-ны манлайлал дор төр, хувийн хэвшил болон иргэний нийгмийн төлөөллүүдийн өргөн оролцоотойгоор Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах ажлыг эхлүүлээд байна.

Төслийн хүрээнд дээрх үйл явцыг дэмжих зорилгоор нэг үндэсний зөвлөхийг 4-12 сард ГХЯ-ны ажлын хэсгийн дэргэд ажиллуулж, Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөний үндсэн суурь болох Бизнес ба хүний эрхийн үндэсний суурь үнэлгээг боловсруулан гаргав. Суурь үнэлгээг холбогдох талуудаар хэлэлцүүлэх салбарчилсан цуврал хэлэлцүүлгүүд явагдаж эхэлсэн ба КОВИД-19 вирусийн хөл хорионы улмаас түр хойшлоод байна. Үүнд уул уурхай, хөдөө аж ахуй, жендэр, шүүх, хууль зүй, төр, иргэний нийгэм зэрэг салбаруудын тусгайлсан хэлэлцүүлгүүд явагдана.



1.4 Бизнес ба Хүний Эрхийн Талаарх Талуудын Чадавхыг Бэхжүүлэх Үйл Ажиллагаа

Бизнес ба хүний эрхийн асуудал нь Монгол улсын хувьд шинэ тутам сэдэв тул талуудын мэдлэг мэдээлэл бүх шатанд хангалтгүй байгааг харгалзан НҮБХХ-ийн Бангкок дахь бүсийн төв оффис, Ази Номхон далайн Бизнес ба Хүний Эрхийн Хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр ГХЯ-тай хамтран Бизнес ба Хүний эрхийн гүнзгийрүүлсэн сургалтыг 9-р сарын 24-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгуулав. Сургалтад Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийн гишүүд болон хэрэгжүүлэх салбар бүрээс 100 гаруй төлөөлөл хамрагдав. Энэхүү сургалт нь улсын хэмжээнд энэ чиглэлийн мэдлэг, мэдээлэл олгох анхны томоохон хэмжээний арга хэмжээ гэдгээрээ чухал ач холбогдолтой үйл ажиллагаа болсон.



Мөн төслийн хүрээнд бизнес ба хүний эрхийн талаарх талуудын мэдлэг мэдээллийг сайжруулах гарын авлага, тараах материал, видео шторкийг Монгол хэл дээр боловсруулан гаргаж талуудын хүртээл болгож байна. Эдгээрийг дараах линкээр орж үзнэ үү:

Бизнес ба хүний эрхийн үндсэн зарчмууд: <https://bit.ly/3cm0DPn>

Бизнес ба хүний эрхийн талаарх цуврал видео: <https://bit.ly/2ScyqBe>

1.5 Уул уурхайн улмаас байгаль орчин доройтож, экологийн хохирол учирч буй газруудад хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх, үнэлгээний аргачлал боловсруулах

Төслийн хүрээнд ХЭҮК-той гэрээ байгуулан Таван толгойн бүлэг ордын нүүрс олборлох тээвэрлэх үйл ажиллагааны хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ (ХЭНБҮ)-ний хэрэгжилтийн мониторинг хийж, ХЭНБҮ-ний гарын авлага боловсруулан, сургалт сурталчилгааны ажлыг хэрэгжүүлэв.

Энэ ажлын хүрээнд төслийн дэмжлэгээр 2018 онд хийсэн "Таван толгойн бүлэг ордын нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагааны хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ" -нээс гарсан нийт долоон бүлэгт хамаарах 42 зөвлөмжийн

хэрэгжилтэд талуудын оролцоотой хамтарсан мониторинг хийв.

Хамтарсан баг байгаль орчин, орчны бохирдол, нүүрс тээврийн аюулгүй байдал, жолооч нарын хөдөлмөрийн харилцаа, иргэдийн эрүүл мэнд зэрэгт холбогдох зөвлөмжийн хэрэгжилттэй танилцах, дүн шинжилгээ хийх зорилгоор 2020 оны 10 дугаар сарын 26-31-ний өдрүүдэд Өмнөговь аймгийн Даланзадгад, Цогтцэций, Ханбогд сумдад ажиллав. Хамтарсан багийг ХЭҮК-ын Тамгын газрын дарга Ч.Алтангэрэл

ахалж, бүрэлдэхүүнд нь БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын дарга Д.Батмөнх, МХЕГ-ын Геологи, уул уурхайн хяналтын хэлтсийн улсын байцаагч Б.Батбаатар, ЦЕГ-ын Экологийн цагдаагийн албаны Эрүүгийн мөрдөгч Р.Гансүх, НҮБХХ-ийн "Байгалийн нөөцийн тогтвортой удирдлагыг хангах байгаль орчны засаглал" төслийн зохицуулагч Р.Ариунбилэг нар болон ХЭҮК-ын Тамгын газрын ажилтнууд ажиллав.

Ажлын хэсэг 10 дугаар сарын 27-29-ний өдрүүдэд Өмнөговь аймгийн, Цогтцэций суманд ажиллаж, тус сумын Засаг дарга О.Бадарч, Тамгын газрын албан хаагчид, уул, уурхайн болон Гашуунсухайт авто замын компаниудын төлөөлөлтэй уулзаж, зөвлөмжийн хэрэгжилттэй биечлэн танилцаж, нөхцөл байдлын үнэлгээг хийлээ. Тухайлбал, дээрх сумын төвийн болон Тавантолгойн 3 уурхай орчны агаарын чанар, тоосжилтын хяналт шинжилгээ хийх аргачлал, давтамж, мэдээллийн

ил тод байдлыг сайжруулах, Эрдэнэс Тавантолгой компанийн уурхайгаас Гашуунсухайтын зам хүртэлх нүүрс тээвэрлэлтийн, уурхайн кемп болон сумын төвийн шороон замыг хатуу хучилттай болгох, нүүрс тээврийн зам дагуух хоолны газар, засвар үйлчилгээний газрууд болон шинээр баригдаж буй Тээвэрчдийн хотхоны бүтээн байгуулалт, мөн 10 дугаар сарын 29-31-нд Ханбогд сум, Гашуунсухайт боомтын чиглэлд нүүрс тээврийн замын дагуу нийгмийн хэв журам сахиулах, замын хөдөлгөөний дүрэм мөрдүүлэх, жолооч нарын хөдөлмөрлөх нөхцөлийн талаар газар дээр нь танилцлаа.



Одоогоор хүний эрхэд нөлөөлөх байдлын 2018 оны үнэлгээнд туссан байгаль орчин, орчны бохирдол, нүүрс тээврийн аюулгүй байдал, жолооч нарын хөдөлмөрийн харилцаа, иргэдийн эрүүл мэнд зэрэгт холбогдох 42 зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэх, илтгэх хуудас боловсруулах ажил хийгдэж байна.

Төслийн хүрээнд "Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх нь" гарын авлагыг нийт 70 хуудас агуулгын хүрээнд боловсруулсан. Энэхүү гарын авлагын хамт "Таван толгойн бүлэг ордын Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ"-ний тайлан, түүний санал зөвлөмжийн хэрэгжилтийн байдлыг нэгтгэн энэ онд багтан хэвлүүлэхээр бэлтгэж байна.

"Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх нь" гарын авлагыг Тавантолгойн бүлэг ордын нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагааны жишээн дээр орчин үеийн онол, арга зүй, практик жишээнд тулгуурлан боловсруулав. Мөн НҮБ-

ын Хүний эрхийн хөтөлбөр, Швед Улсын Байгаль орчны агентлагаас хамтран гаргасан Extracting Good Practices: A Guide for Governments and Partners to Integrate Environment and Human Rights into the Governance of the Mining Sector сургалтын гарын авлагын загвар, дизайныг баримталж ажиллав.

Мөн төслийн хүрээнд "Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх ба хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх нь" ТВ шторк хийх, ХЭҮК-ын болон бусад мэдээллийн хэрэгслүүд, олон нийтийн сүлжээгээр олон нийтэд түгээх, Таван толгойн бүлэг ордын нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагааны хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ (2018)-ний зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийсэн талаар олон талт зөвлөлдөх уулзалт зохион байгуулах зэрэг ажил явагдаж байна.



2

ЗОРИЛТОТ ГАЗРУУДАД ХАМТЫН ОРОЛЦООТ БАЙГАЛЬ ОРЧНЫ МОНИТОРИНГ (ХОБОМ) НЭВТРҮҮЛЭХ ЖИШИГ ҮЙЛ АЖИЛЛАГАА ТУРШИН ХЭРЭГЖҮҮЛЭХ

2.1

ЗОРИЛТОТ ГАЗРУУДАД ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ТАЛУУДЫН ОРОЛЦООТОЙ ХАМТЫН ОРОЛЦООТ БАЙГАЛЬ ОРЧНЫ МОНИТОРИНГ ТУРШИЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ

Төслийн хүрээнд БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 05-р сарын 21-ны өдөр баталсан удирдамжийн дагуу 06-р сарын 09-11-ны өдрүүдэд Хэнтий аймгийн Норовлин сумын нутаг дахь Дацан Трейд ХХК-ийн алтны шороон орд, Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын нутаг дахь Говь Мастер ХХК-ийн жоншны уурхайн үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын оролцоотой байгаль орчны мониторинг хийж жишиг үнэлгээний аргачлалыг туршив.

Хамтарсан мониторингийн багт БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн

удирдлагын газрын Байгаль орчин үнэлгээ, аудитын хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Шижир-Эрдэнэ, мэргэжилтэн М.Тулга, УУХҮЯ-ны Геологи, уул уурхайн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Уул уурхай хэлтсийн мэргэжилтэн Б.Отгонбаяр, МХЕГ-ын Геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч Б.Батбаатар, ХЭҮК-ын Тамгын газрын дарга Ч.Алтангэрэл, ЦЕГ-ын Экологийн цагдаагийн албаны Эрүүгийн цагдаагийн хэлтсийн эрүүгийн мөрдөгч, цагдаагийн ахлах дэслэгч Г.Гансүх, Монголын байгаль орчны иргэний зөвлөлийн Ногоон парламентын гишүүн Л.Отгонцэцэг, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн төслийн зохицуулагч

Р.Ариунбилэг, Хэнтий аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн Г.Мөнх-Эрдэнэ, Норовлин сумын Засаг дарга П.Алтангэрэл, Сүхбаатар аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн Ш.Нямхүү, Түмэнцогт сумын Байгаль орчны мэргэжилтэн Э.Шүрэнцэцэг, Дацан Трейд ХХК-ийн Гүйцэтгэх захирал Э.Батсайхан, Уурхайн дарга Т.Түвшинбат, Говь Мастер ХХК-ийн Гүйцэтгэх захирал С.Мөнхтуяа, Менежер О.Шинэдарам нар ажиллав.

Мониторингийн баг хамтын оролцоот байгаль орчны мониторинг хийх жишиг хяналтын хуудсыг хамтран боловсруулж бэлтгэв. Зорилтот уурхай дээр мониторинг хийх үед оролцогч бүх талууд өөр өөрийн үйл ажиллагааны чиглэлийн дагуу холбогдох мэдээллийг солилцож,

уурхайн үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, урьдчилсан боловсруулсан хяналтын хуудасны дагуу байгаль орчны хууль тогтоомж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт өгч, нээлттэй хэлэлцүүлэг явуулж, биелэлтийг сайжруулах чиглэлээр талууд холбогдох зөвлөмжийг өгөв.

Уул уурхайн үйл ажиллагаанд талуудын оролцоот хамтарсан мониторинг хийх нь тэдний харилцан ойлголцол, хамтын ажиллагааг бэхжүүлэх, улмаар уул уурхайтай холбоотой зөрчлийг бууруулах, үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой механизм болохыг бүх талууд онцолж энэ ажлын хүрээнд боловсруулж туршсан хяналтын хуудсыг ашиглан энэ туршлагыг уурхай бүхий бүс нутгуудад хэрэгжүүлэх нь зүйтэй гэж дүгнэсэн.



2.2

ЗОРИЛТОТ ГАЗРУУДАД ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛГА БОЛОН ОРОН НУТГИЙН САНААЧИЛГАТАЙ ХАМТЫН ОРОЛЦООТ БАЙГАЛЬ ОРЧНЫ МОНИТОРИНГИЙН ЖИШИГ ҮЙЛ АЖИЛЛАГАА ТУРШИН ХЭРЭГЖҮҮЛЭХ, ПРАКТИК ГАРЫН АВЛАГА БИЙ БОЛГОХ



Төслийн хүрээнд нутгийн иргэдэд түшиглэсэн хамтын оролцоотой байгаль орчны мониторинг (ХОБОМ)-ын үйл ажиллагааг орон нутагт турших, үндэсний онцлогт нийцсэн ХОБОМ-ын цогц аргачлалыг боловсруулж сайн туршлага болгон дэлгэрүүлэх ажлыг Хил хязгааргүй алхам ТББ-тай гэрээ байгуулан гүйцэтгэж байна. Энэ ажлын хүрээнд Төв аймгийн Баянжаргалан, Дорноговь аймгийн Айраг, Даланжаргалан сумдад ХОБОМ-ын зөвлөлүүд албан ёсоор байгуулагдан, зөвлөлийн гишүүдэд цуврал сургалтууд зохион байгуулан, хэд хэдэн уурхай дээр ХОБОМ-ын дадлага ажил хийгдэв. Эдгээр практик ажлууд болон олон улсын туршлагад үндэслэн Хил хязгааргүй алхам ТББ-ын ХОБОМ-ын гарын авлагын эхний төслийг боловсруулаад байна.

Хэрэгцээ тодорхойлох судалгааны дүнд Төв аймгийн Баянжаргалан суманд хөрс, ус, ургамлын мониторинг, Дорноговь аймгийн Айраг, Даланжаргалан сумдад химийн бодисын менежмент, химийн аюултай хог хаягдлын мониторинг тус тус хийхээр тогтсоны дагуу эдгээр 3 суманд 5 чиглэлээр ХОБОМ хийх загвар аргачлал боловсруулан, багийн гишүүдэд холбогдох сургалтыг явуулав. Дадлага ажлыг Төв аймгийн Баянжаргалан сумын нутагт Цэцэн майнинг ХХК, Дорноговь аймгийн Айраг сумын нутагт Янтай уул ХХК, Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт Эко хэлхээ ХХК-ийн талбарт тус тус явуулж туршиж байна.

Химийн бодисын менежмент, аюултай хог хаягдлын мониторинг хийхдээ Янтай уул ХХК-д хамаарал бүхий 15 цэгээс, Эко хэлхээ ХХК-ны баяжуулах үйлдвэртэй холбогдох 15 цэгээс химийн мэргэжилтнүүдийн зааварчилгаа,

удирдлага дор цэгээ тогтоон дээж авч 2 удаагийн шинжилгээг Геологийн төв лаборатори, Хими, химийн технологийн хүрээлэнгийн лабораторид хийлгэв.

Хөрс, ус, ургамлын мониторинг хийх аргачлал боловсруулах, дадлага ажил хийхэд БОНБУ-ний Эко трейд консалтинг ХХК-ийн экологийн мэргэжилтэн Н.Анхбаяр, Цэцэн майнинг ХХК-ны байгаль орчны мэргэжилтэн Н.Даваасүрэн, химийн бодисын менежмент, аюултай хог хаягдлын мониторинг хийхэд ШУА-ийн Хими, химийн технологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Др.Ж.Бурмаа, эрдэмтэн нарийн бичгийн дарга Др.Б.Нарандалай нартай хамтран ажиллалаа.

КОВИД-19 вирусийн хөл хорионоос хамааран зарим сургалт, хээрийн дадлага ажил хойшилсон тул Хил хязгааргүй алхам ТББ-ын гэрээт ажлыг 2021 оны 02-р сарын 28 хүртэл сунгаад байна.



Зорилтот сумдад байгуулагдсан ХОБОМ-ын зөвлөлийн бүрэлдэхүүн

АЙМАГ, СУМ	НИЙТ ГИШҮҮДИЙН ТОО	ҮҮНЭЭС ЭМЭГТЭЙ	БҮРЭЛДЭХҮҮН		
			УУЛ УУРХАЙН КОМПАНИ	ОРОН НУТГИЙН ЗАХИРГАА	ИРГЭД, ТББ
ТӨ: Баянжаргалан	15	9	2	7	6
ДГ: Айраг	15	8	1	5	9
ДГ: Даланжаргалан	20	10	2	5	13
ДҮН	50	26	5	17	18



Зорилтот сумдын ХОБОМ-ын зөвлөлийн гишүүдэд зохион байгуулсан сургалтууд

ОГНОО	ХААНА	СЭДЭВ	ОРОЛЦОГЧДЫН ТОО	ҮҮНЭЭС ЭМЭГТЭЙ
2020.09.11	Төв, Баянжаргалан	ХОБОМ үнэлгээ, түүний аргачлал, байгаль орчин, уул уурхайн салбарын хууль тогтоомж	25	16
2020.09.18	Төв, Баянжаргалан	Төрийн албан хаагчдад хууль тогтоомжийн дагуу хариуцлага шаардах, баримт бичгүүдэд тулгуурласан хяналт шалгалт хийх	18	12
2020.09.19	Төв, Баянжаргалан	Иргэд, нөлөөллийн бүсийн иргэдэд ХОБОМ хийх ажлын хэсэгт ажиллах, мэдээлэл авах, утга учиртай оролцооны хэлбэрүүд, дадлага ажил	24	16
2020.09.21-22	Дорноговь, Айраг	ХОБОМ үнэлгээ, түүний аргачлал, химийн бодисын хэрэглээ, химийн аюултай хог хаягдлын хууль тогтоомж, мониторинг хийх аргууд	23	16
2020.09.23	Дорноговь, Даланжаргалан	ХОБОМ үнэлгээ, түүний аргачлал, химийн бодисын хэрэглээ, химийн аюултай хог хаягдлын хууль тогтоомж, мониторинг хийх аргууд	21	10
2020.10.17	Төв, Баянжаргалан	Цэцэн майнинг ХХК-ны талбайд ХОБОМ хийх дадлага ажил, хэлэлцүүлэг	16	9
2020.10.22	Дорноговь, Айраг	ХОБОМ үнэлгээний аргачлалын төсөлд санал авах, ажлын хэсгийн дүрэм хэлэлцэх, зөвлөл албажуулах	13	8
2020.10.23	Дорноговь, Даланжаргалан	ХОБОМ үнэлгээний аргачлалын төсөлд санал авах, ажлын хэсгийн дүрэм хэлэлцэх, зөвлөл албажуулах	21	13
			161	100



3

“ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН ЖИШИГ ШААРДЛАГА”-ЫГ НЭВТРҮҮЛЭХ ЖИШИГ ҮЙЛ АЖИЛЛАГАА ТУРШИН ХЭРЭГЖҮҮЛЭХ

3.1

“ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН ЖИШИГ ШААРДЛАГА”-ЫГ УУЛ УУРХАЙН КОМПАНИУДАД НЭВТРҮҮЛЭХ ЖИШИГ ҮЙЛ АЖИЛЛАГАА

“Хариуцлагатай уул уурхайн жишиг шаардлага”-ыг нэвтрүүлэх ажлыг Монголын уул уурхайн үндэсний ассоциаци (МУУҮА)-тай гэрээ байгуулан хэрэгжүүлж байна. Энэ ажлын хүрээнд жишиг шаардлагыг нэвтрүүлэх сургалтын модуль боловсруулагдан, сургагч багш бэлтгэгдэн, эхний ээлжид 12 компанийг сургалтад хамруулан өөрийн үнэлгээний тайланг боловсруулах ажил хийгдэж байна. Мөн сайн туршлагыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажил төлөвлөсөн.

МУУҮА төслийн хүрээнд 2018 онд боловсруулсан “Хариуцлагатай уул уурхайн жишиг шаардлага, үнэлгээний аргачлал”-д суурилан “Хариуцлагатай уул уурхайн сайн дурын кодекс” (ХУУК), түүнийг хэрэгжүүлэх заавар, мөн хэрэгжилтэд үнэлгээ хийх зааврын хамтаар боловсруулан өөрийн гишүүн 12 компаниудад сургалт явуулж, компаниудын үйл ажиллагаанд кодексийг нэвтрүүлэх ажлыг 6-р сараас хэрэгжүүлж байна.

“Хариуцлагатай уул уурхайн кодекс” сургалтын модулийн төслийг холбогдох талуудад танилцуулан санал авах хэлэлцүүлгийг 09-р сард НҮБ-ын байранд зохион байгуулав. Хэлэлцүүлэгт УУХҮЯ, БОАЖЯ, ХЭҮК, МХЕГ, МЕРИТ төсөл, Хариуцлагатай уул уурхай ТББ болон НҮБХХ-ийн төлөөлөл оролцож санал солилцож, зөвлөмж өгөв. МУУҮА-ийн баг талуудын зөвлөмжийг нэгтгэн кодексын төсөлд тусгаж, компанийн сургалтыг эхлүүлсэн.

Одоогийн байдлаар Терра Энержи ХХК, Багануур ХК, Оюу толгой ХХК, Монполимет ХХК, Аспайр Майнинг ХХК, Эрдэнэ Ресурс ХХК, МоЭнко ХХК сургалтад хамрагдсан ба КОВИД-19 вирусийн хөл хорионоос болж төлөвлөсөн танхимын сургалтууд хойшилсон ч МУУҮА-ийн баг сургалтыг цахим хэлбэрт шилжүүлэн үргэлжлүүлэн зохион байгуулж байна. Үүнтэй холбогдуулан гэрээт ажлыг 2021 оны 02 сарын 28 хүртэл сунгасан. Энэ хугацаанд төлөвлөсөн сургалтуудыг дуусган,



компаниудын хариуцлагатай уул уурхайн өөрийн үнэлгээний тайлан гаргах, гэрээт ажлын эцсийн тайлан, зөвлөмж танилцуулах ажлууд хийгдэхээр төлөвлөж байна. Компаниудын хувьд олборлолт явагдаагүй, бүтээн байгуулалт, бэлтгэл ажлын үе таарч байгаа учир цаг үеэ олсон хэрэгтэй сургалт явуулсанд талархаж хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, үр дүнтэй хэрэгжүүлэх эрмэлзэлтэй байгаагаа илэрхийлж байна.

Энэхүү ажил нь Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогод туссан хариуцлагатай уул уурхайн зарчмыг нэвтрүүлэх зорилттой уялдан хэрэгжиж байгаа бөгөөд ХУУК нэвтрүүлсний үр дүнд уул уурхайн компаниудад доорх 4 түвшинд өөрчлөлт гарна гэж зорьж байгаа юм.

Одоогийн байдлаар Терра Энержи ХХК, Багануур ХК, Оюу толгой ХХК, Монполимет ХХК, Аспайр Майнинг ХХК, Эрдэнэ Ресурс ХХК, МоЭнко ХХК сургалтад хамрагдсан ба КОВИД-19 вирусийн хөл хорионоос болж төлөвлөсөн танхимын сургалтууд хойшилсон ч МУУҮА-ийн баг сургалтыг цахим хэлбэрт шилжүүлэн үргэлжлүүлэн зохион байгуулж байна. Үүнтэй холбогдуулан гэрээт ажлыг 2021 оны 02 сарын 28 хүртэл сунгасан. Энэ хугацаанд төлөвлөсөн сургалтуудыг дуусган,

компаниудын хариуцлагатай уул уурхайн өөрийн үнэлгээний тайлан гаргах, гэрээт ажлын эцсийн тайлан, зөвлөмж танилцуулах ажлууд хийгдэхээр төлөвлөж байна. Компаниудын хувьд олборлолт явагдаагүй, бүтээн байгуулалт, бэлтгэл ажлын үе таарч байгаа учир цаг үеэ олсон хэрэгтэй сургалт явуулсанд талархаж хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, үр дүнтэй хэрэгжүүлэх эрмэлзэлтэй байгаагаа илэрхийлж байна.

Энэхүү ажил нь Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогод туссан хариуцлагатай уул уурхайн зарчмыг нэвтрүүлэх зорилттой уялдан хэрэгжиж байгаа бөгөөд ХУУК нэвтрүүлсний үр дүнд уул уурхайн компаниудад доорх 4 түвшинд өөрчлөлт гарна гэж зорьж байгаа юм.





4

УУЛ УУРХАЙН САЛБАР ДАХЬ БАЙГАЛЬ ОРЧНЫ ЗАСАГЛАЛЫН ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫГ ЧАДАВХЖУУЛАХ



4.1

Мэргэжлийн хяналтын байцаагчдын гарын авлага дахин хэвлэл

Төслийн хүрээнд 2018 онд боловсруулж хэвлүүлсэн "Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтад хүний эрх, хууль дээдлэх зарчмыг хангах нь: Байгаль орчны холбогдолтой зөрчлийн хэргийг шалгах аргачлал" мэргэжлийн хяналтын байцаагчдад зориулсан гарын авлагыг дахин 500 хувь хэвлэн МХЕГ-т хүлээлгэн өгч төв, орон нутгийн байцаагчдад хүргэв. Мөн цахим хэлбэрээр НҮБХХ-ийн вэбсайтад байршуулав.

4.2

ЭКОЛОГИЙН ЦАГДААГИЙН АЛБАН ХААГЧДЫН СУРГАЛТ

Цагдаагийн ерөнхий газрын Экологийн цагдаагийн албаны аймаг, нийслэл дэх нийт 170 албан хаагчийг хамруулан "Уул уурхайн нөхөн сэргээлт ба химийн хорт болон аюултай бодис, хог хаягдлын менежментийн асуудал" сургалтыг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангасан боловч КОВИД-19 вирусийн хөл хорионы улмаас түр хойшлогдоод байна.

5

ТӨСЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛ БОЛОН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ТАЛУУДЫН ХОЛБОГДОХ МЭРГЭЖИЛТНҮҮДЭЭС БҮРДСЭН ТӨСЛИЙН БАГИЙН УУЛЗАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

5.1

Мэргэжилтнүүдийн уулзалт

Төслийг хамтран хэрэгжүүлэгч байгууллагууд болох БОАЖЯ, УУХҮЯ, МХЕГ, ХЭҮК-ийн холбогдох мэргэжилтнүүдтэй төслийн төлөвлөлт болон хэрэгжилтэд хамтран ажиллаж, санал солилцох уулзалт хэлэлцүүлгийг 2 болон 6 сард тус тус зохион байгуулсны зэрэгцээ төслийн үйл ажиллагаануудыг талуудын хамтын оролцоонд тулгуурлан хэрэгжүүлэхийг зорьж ажиллалаа. Төслийн хэрэгжилтийн явцыг оролцогч талуудад улирал тутам мэдээлэн тэдний санал зөвлөмжийг тусгаж ажиллав. Мөн төслийн хүрээнд зохион байгуулсан орон нутагт хамтын оролцоот байгаль орчны мониторинг болон хүний эрхийн үнэлгээ хийх ажлуудад талууд хамтран баг болж ажилласан нь бодлого үйл ажиллагааны уялдааг хангах, талуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх чухал үйл ажиллагаа болсон.

5.2

Төслийн олон улсын туршлага солилцох семинар

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Нью-Йорк дахь Төв оффисоос төсөл хэрэгжиж буй 10 орны дунд туршлага солилцох, оны үр дүнг хэлэлцэх онлайн семинарыг 11-р сарын 10-12-ны өдрүүдэд зохион байгуулсанд НҮБХХ, БОАЖЯ, ХЭҮК, Хил хязгааргүй алхам ТББ-ын төлөөлөл бүхий Монголын баг оролцож 2020 оны төслийн үр дүнгээ танилцуулав.

5.3

Төслийн удирдах зөвлөлийн хурал

Төслийн Удирдах зөвлөлийн хурлын 12 дугаар сарын 21-25-ны хооронд зохион байгуулна.





6

ТӨСЛИЙН ҮР ДҮН

2020 онд төслийн өмнөх жилүүдийн үр дүн, үйл ажиллагааг үргэлжлүүлэн, уул уурхайн салбарт байгаль орчны засаглалыг бэхжүүлэхэд чиглэсэн сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, жишиг үйл ажиллагааг турших, хууль эрхзүйн орчин, хэрэгжилтийн механизмыг сайжруулах чиглэлээр ажилласнаар дараах үр дүн гарсан гэж дүгнэж байна. Үүнд:

- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тогтолцоонд төвлөрлийг сааруулах, үнэлгээний чанар, бүтээмжийг нэмэгдүүлэх боломжийн талаар үнэлгээ хийж, цаашид эрхзүйн шинэчлэл хийх суурь мэдээллийг бэлтгэв.
- Уул уурхайн болон аливаа төсөл хөтөлбөрт хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх гарын авлага бий болов.
- Уул уурхай бүхий бүс нутгуудад хамтын оролцоот байгаль орчны мониторинг хийх практик гарын авлага, аргачлал бий болов.
- Хариуцлагатай уул уурхайн кодекс, зааварчилгаа, сургалтын модуль бий болж уул уурхайн компаниуд үйл ажиллагаандаа нэвтрүүлж эхлэв.
- Бизнес ба хүний эрхийн үндэсний суурь үнэлгээ хийгдэж үндэсний хөтөлбөр боловсруулах ажилд ахиц дэвшил гарав.
- НҮБХХ-ийн вэбсайтад төслийн вэб хуудсыг нээж, төслийн хүрээнд сүүлийн жилүүдэд боловсруулсан гарын авлага материалуудыг байршуулав. Мөн НҮБХХ-ийн социал сувгуудаар төслийн үйл ажиллагааны талаар олон нийт болон холбогдох талуудад цаг тухай бүрд мэдээ мэдээлэл түгээж ажиллав.

ТӨСЛИЙН ВЭБ ХУУДАС: [HTTPS://WWW.MN.UNDP.ORG/CONTENT/MONGOLIA/EN/HOME/PROJECTS/ENVIRONMENTAL-GOVERNANCE-FOR-SUSTAINABLE-NATURAL-RESOURCE-MANAGE0.HTML](https://www.mn.undp.org/content/mongolia/en/home/projects/environmental-governance-for-sustainable-natural-resource-manage0.html)



НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр
“Байгалийн нөөцийн тогтвортой удирдлагыг хангах байгаль
орчны засаглал” төсөл
Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг
Нэгдсэн Үндэстний Гудамж-14
Утас: 976-11-327585, Факс: 976-11-326221
И-мэйл: registry.mn@undp.org
www.mn.undp.org